



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар Д/25

Мөрөн сум

**Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн
орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолын хавсралт Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын 1.3.2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга
Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер
Соёлын төвийн дарга
Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч
Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Эх хэлний багш
Насан туршийн боловсролын багш

2.Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА
Н.ХАТАНБААТАР